

Аудитын код: САГ-2018/15/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Цэрэндорж
Утас: 261740 Цахим хаяг: tserendorjd@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн: “Лайэн Аудит” ХХК
Аудитор Г.Дэлгэрцэцэг
Утас: 70126778 Цахим хаяг: lionaudit@yahoo.com



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	2
2.5	Дотоод хяналт.....	3
2.6	Орлого, зарлагын талаарх тайлбар, тодруулга.....	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	3
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	3
2.9.1	Авлага, өглөгийн талаар.....	3
2.9.2	Эздийн өмчийн бусад хэсгийн талаар.....	4
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	4
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	4
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	4
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	4
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	4
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	4
3	Менежментийн захидал	6
3.1	Авлага, өглөгийн талаар	7
3.2	Эздийн өмчийн бусад хэсгийн талаар	8
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	9
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	9
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	10
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12

“МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ” ТӨҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ж.СОЛОНГО ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2017оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг, хариуцлага

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2 Аудитын тайлан

2.1 Оршил

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын захирал Ж.Солонго танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах, эздийн өмчийн бусад хэсгийг зөв тайлагнах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.


Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналынолон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын удирдлага санхүүгийн тайлангаа Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 14-нөөс 2018 оны 3 дугаар сарын 12-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-нд үзэсгэлэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Лайон аудит”



ХХК-ийн аудитор Г.Дэлгэрцэцэг, аудиторын туслах Ү.Цэнджав нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа захирлын 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 13 дугаар албан бичгээр Лайэн аудит ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан тодруулгыг бэлтгэх заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын эрхэм зорилго нь “Уран сайхны болон баримтат кино бүтээж түүгээр дамжуулан Монгол орны түүх, өв уламжлал, ёс заншил, үндэсний бахархлыг хойч үедээ амьд дуу, дүрсээр өвлүүлэн үлдээх” юм.

Кино хальс боловсруулах, баримтат болон уран сайхны кино бүтээх үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд кино группэд шаардлагатай хувцас хэрэглэл тоног төхөөрөмжийн үйлчилгээ үзүүлэх туслах үйл ажиллагаа явуулж байна.

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 5 чиглэлээртүүвэрчилсэн байдлаар аудитын 15 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн програм хангамжгүгээс excel програм ашиглаж бэлтгэсэн бөгөөд үүнээс шалтгаалан бүртгэл шаардлага хангахуйц хэмжээнд хөтлөгдөж үзүүлж байна. Тухайлбал: ерөнхий журнал, ерөнхий дэвтэр туслах журналууд хөтлөгдөхгүй байх шаардлагатай тайлан тоон мэдээлэлүүд гарахгүй байх, тайлангийн уялдаа холбоо

алдагдах, мэдээлэл харахад хугацаа их шаардагдах зэрэг хүндрэл гарч байна. Цаашид сангийн яамнаас хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн програм хангамж зайлшгүй авч хэрэглэх шаардлагатай байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

2.6 Орлого, зарлагын талаарх тайлбар, тодруулга

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ нь 2017 онд үндсэн үйл ажиллагаанаас 236.9 сая, түрээсийн орлого 42.8 сая, хүүний орлого 4.9 сая, бусад орлого 7.8 сая, нийт 292.4 сая төгрөгийн орлого олж үндсэн үйл ажиллагааны зардалд 283.5 сая, бусад зардалд 8.2 сая, нийт 291.7 мянган төгрөгийн зардал гаргаж 0.5 сая төгрөгийн орлогын албан татвар ногдуулж, 0.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ нь Шилэн дансны цахим хуудас www.shilendans.gov.mn-т хагас жилийн санхүүгийн тайлан, 2018 оны зорилтот түвшингийн төсөл болон цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 3 гүйлгээ буюу 18.5 сая НӨАТ болон ХХОАТ шилжүүлсэн зардлын 108.9 сая төгрөгийн орлогын 1 гүйлгээ зэргийг байршуулж олон нийтэд ил тод мэдээлсэн байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр, нийт 15 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.


Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Авлага, өглөгийн талаар

Дансны авлага 9.0 сая, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 1.6 сая, бусад авлага 3.4 сая, нийт 14.1 сая төгрөгийн авлага, дансны өглөг 3.3 сая татварын өр 1.4 сая, нийт 4.7 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар тулган баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийж, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” гэж заасныг зөрчсөн байна.



Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах, авлага, өглөгийг барагдуулах арга хэмжээ авах, цаашид алдааг давтан гаргахгүй талаар зөвлөмж хүргүүлэх;

2.9.2 Эздийн өмчийн бусад хэсгийн талаар

Эздийн өмчийн бусад хэсэгт газар эзэмших эрхийн дахин үнэлгээ 345.6 сая, төрийн өмчийн хорооны шийдвэрээр балансас балансд үндсэн хөрөнгө шилжүүлж авсан 597.9 сая, нийт 943.5 сая төгрөгийг бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын 1 дүгээр хавсралтын 2 дугаар бүлэгт Эздийн өмчийн бусад хэсэгт “бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч өмчийн хэсэгт хуримтлуулан бүртгэсэн бусад олз, гарзындүнг толилуулна” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалыг мөрдөж ажиллах, залруулж бүртгэх зөвлөмж хүргүүлэх.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Төрийн өмчийн хөрөнгийг түрээслүүлэн олсон орлогоос 20%-ийг төсөвт төвлөрүүлээгүй, худалдаа хөгжлийн банкны харилцах дансны 2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэлд тайлагнагдсан 2017 оны 12 сарын 25-нд орж ирсэн 108.9 сая төгрөгийг тайлант жилд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 962.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба аудитын явцад 943.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулж, 18.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэх.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 4 зөвлөмж өгөгдсөн байна. Өгөгдсөн 3 зөвлөмжийг бүрэн биелүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.


2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгов.

“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2017 оны санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгө 1,815.1 сая төгрөг бөгөөд 1.0 хувиар буюу 18.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.



“Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Авлага, өглөгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Дансны авлага 9.0 сая, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 1.6 сая, бусад авлага 3.4 сая, нийт 14.1 сая төгрөгийн авлага, дансны өглөг 3.3 сая татварын өр 1.4 сая, нийт 4.7 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар тулган баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчигдөх, авлага төлөгдөхгүй байх.

ҮАГ-ын зөвлөмж

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах,
- Авлага, өглөгийг барагдуулах арга хэмжээ авах,
- Цаашид алдааг давтан гаргахгүй байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын үйлчлүүлэгчийн санхүүгийн танилцуулсан болно.

бүртгэлийг удирдлага, ажилтанд



3.2 Эздийн өмчийн бусад хэсгийн ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Эздийн өмчийн бусад хэсэгт газар эзэмших эрхийн дахин үнэлгээ 345.6 сая, төрийн өмчийн хорооны шийдвэрээр балансаас балансад үндсэн хөрөнгө шилжүүлж авсан 597.9 сая, нийт 943.5 сая төгрөгийг бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын 1 дүгээр хавсралтын 2 дугаар бүлэгт Эздийн өмчийн бусад хэсэгт “бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч өмчийн хэсэгт хуримтлуулан бүртгэсэн бусад олз, гарзындүнг толилуулна” гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

ҮАГ-ын зөвлөмж

Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ыг мөрдөж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын үйлчлүүлэгчийн санхүүгийн танилцуулсан болно.

бүртгэлийг удирдлага, ажилтанд



4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	2016.12.31	2017.12.31
Хөрөнгө		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	208 540 122,14	203 423 621,42
Дансны авлага	11 556 203,67	13 338 504,12
Татвар, НДШ-ийн авлага	1 273 124,81	1 630 305,83
Бусад авлага	35 240 850,39	37 817 679,13
Бараа материал	199 507 664,51	231 926 213,89
Эргэлтийн хөрөнгийн дүн	456 117 965,52	488 136 324,39
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	1 010 657 306,48	981 348 974,75
Биет бус хөрөнгө	345 580 118,40	345 580 118,40
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1 356 237 424,88	1 326 929 093,15
Нийт хөрөнгө	1 812 355 390,40	1 815 065 417,54
Өр төлбөр		
Богино хугацаатай өр		
Дансны өглөг	612 745,07	3 281 321,57
Цалингийн өглөг		11 460,29
Татварын өр	1 543 468,56	1 435 404,51
НДШ-ийн өглөг	20 699,91	
Бусад богино хугацаат өр төлбөр	260 000,00	250 000,00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	2 436 913,54	4 978 186,37
Урт хугацаат өр		
Урт хугацаат зээл		
Урт хугацаат өр төлбөрийн дүн		
Нийт өр төлбөр	2 436 913,54	4 978 186,37
Эздийн өмч		
Эзний өмч	124 660 692,93	124 660 692,93
Нэмж төлөгдсөн капитал		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	767 847 936,36	1 113 428 054,76
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	943 452 491,72	
Хуримтлагдсан ашиг	(26 042 644,15)	571 998 483,49
Эздийн өмчийн дүн	1 809 918 476,86	1 810 087 231,18
Нийт өр ба эзний өмчийн дүн	1 812 355 390,40	1 815 065 417,55

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	<i>/төгрөгөөр/</i>	
	2016.12.31	2017.12.31
Үндсэн үйл ажиллагааны орлого	251 280 000,00	236 859 091,55
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	43 751 902,13	
Нийт ашиг	207 528 097,87	236 859 091,55
Түрээсийн орлого	125 158 392,30	42 783 427,27
Хүүний орлого	3 106 480,80	4 907 267,11
Бусад орлого	15 011 862,55	7 815 027,77
Борлуулалт маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	347 520 132,29	283 527 433,40
Хүүгийн зардал		
Бусад зардал	2 965 185,18	8 152 321,00
Гадаад валютын ханшийн зөрүүний олз, (гарз)	17 291,29	(6 827,80)
Татварын өмнөх ашиг	336 807,34	678 231,50
Татварын зардал	310 648,08	509 477,19
Цэвэр ашиг	26 159,26	168 754,31



4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Бүгд
2015 оны 12 сарын 31 ны өдөр	124 660 692,93	767 847 936,36	862 728 718,40	(26 068 803,40)	1 729 168 544,29
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				26 159,26	26 159,26
Бусад дэлгэрэнгүй орлого					
Өмчид гарсан өөрчлөлт			80 723 773,32		80 723 773,32
Зарласан ногдол ашиг					
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
2016 оны 12 сарын 31 ны өдөр	124 660 692,93	767 847 936,36	943 452 491,72	(26 042 644,15)	1 809 918 476,86
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		345 580 118,40	(943 452 491,72)	597 872 373,32	
Залруулсан үлдэгдэл					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				168 754,27	168 754,27
Бусад дэлгэрэнгүй орлого					
Өмчид гарсан өөрчлөлт					
Зарласан ногдол ашиг					
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
2017 оны 12 сарын 31 ны өдөр	124 660 692,93	1 113 428 054,76	-	571 998 483,48	1 810 087 231,18



4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	2016.12.31	2017.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	422 359 637,55	304 419 779,38
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	418 695 171,18	299 262 512,27
Бусад мөнгөн орлого	3 664 466,37	5 157 267,11
Мөнгөн зарлагын дүн	281 648 462,10	276 007 357,76
Ажиллагчдад төлсөн	120 193 215,00	116 771 233,00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	32 352 000,00	30 651 000,00
Бараа материал худалдан авахад төлсөн	7 584 955,00	33 956 828,50
Ашиглалтын зардалд төлсөн	73 487 060,72	45 093 310,25
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3 636 363,64	9 662 040,91
Татварын байгууллагад төлсөн	39 759 817,28	31 257 859,10
Даатгалын төлбөрт төлсөн		462 765,00
Бусад мөнгөн зарлага	4 635 050,46	8 152 321,00
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	140 711 175,45	28 412 421,63
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	11 318 181,82	872 730,00
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	11 318 181,82	
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		872 730,00
Мөнгөн зарлагын дүн	50 837 117,23	34 394 824,54
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	32 608 754,55	30 583 937,98
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	18 228 362,68	3 810 886,56
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(39 518 935,41)	(33 522 094,54)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	5 152 500,00	-
Төрөл бүрийн хандив	5 152 500,00	
Мөнгөн зарлагын дүн	7 297 500,00	6 827,80
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	2 235 000,00	
Гадаад валютын ханшийн зөрүү	5 062 500,00	6 827,80
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2 145 000,00)	(6 827,80)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	99 047 240,04	(5 116 500,72)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	109 492 882,09	208 540 122,14
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	208 540 122,14	203 423 621,42

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ